

Хичээлийн сэдэв: Волейболын үүсэл, хөгжлийг судалж мэдэх

Хамрах хүрээ: Шинэ Эрин сургууль 9-р анги

Волейбол нь Европын, Азийн орнуудад эрт дээр үед үүссэн гэдэг яриа байдаг боловч АНУ-ыг волейболын эх орон гэж үздэг.

Волейболыг анх үндэслэгч нь АНУ-ын Массачусетс мужийн Холлойк хотын дунд сургуулийн биеийн тамирын багш Вильям Морган юм.

В.Морган хэрэглэл материал, хөрөнгө зардал бага шаардагдах энгийн тоглоом бий болгохыг хүсэж байв. В.Морган 1895 онд шинэ тоглоомынхоо дүрмийг боловсруулжээ. Шинэ тоглоомоо “Волейбол” гэж нэрлэв. Волейбол гэдэг нь Англиар “Нисдэг бөмбөг” гэсэн утгатай үг юм.

Волейболын анхны тоглолтыг Спрингфилдэд 1896 оны 7 сард нийтийн өмнө үзүүлсэн байна.

АНУ-д 1897 онд 10 зүйлтэй анхны дүрмийг боловсруулсан. Үүнд:

1. Талбайн тэмдэг
2. Тоглолтонд хамаарагдах зүйлүүд
3. Талбайн хэмжээ 25*50 фут (7.6 м*15.1 м)
4. Торны хэмжээ 2*27 фут (0.6 м* 8.2 м)
5. Торны өндөр 6.5 фут (198 см)
6. Шир буюу маалинган эдээр хийсэн гадартай резинэн бөмбөг. Бөмбөг нь бүслүүрээрээ 25-27 дюйм (63.5-68.5) хүнд нь 340 гр
7. Давуулалт. Тоглогч нэг хөлөөрөө шугаман дээр гишгэж, алгаа тэнийлгэн бөмбөгийг цохино. Хэрэв эхний давуулалтын үед алдаа гаргавал давуулалтыг дахин гүйцэтгэнэ
8. Тоо. Өрсөлдөгчийн давуулалт амжилтгүй болох бүрт 1 оноо авах боломж бүрдэх бөгөөд өөрийн давуулалтын үед оноо авна. Хэрэв давуулалтын дараа бөмбөг нь давуулагч талд унах ба тэр багийнхан алдаа гаргавал давуулагч тоглогчийг өөрчилнө
9. Хэрэв тоглолтын явцад бөмбөг торонд хүрвэл (давуулалтаас гадна) алдаанд тооцно
10. Хэрэв бөмбөг шугаман дээр тусвал алдаанд тооцно
11. Тоглогчдын тоог хязгаарлахгүй гэх мэт зүйлүүд заагдсан байна

Дэлхийн янз бүрийн улс орнуудад волейбол өргөн дэлгэрч эхлэв. Ялангуяа Европ тивд Чехословак, Франц, ЗХУ-д маш хурдтай дэлгэрчээ. Волейбол өргөн дэлгэр хөгжихийн зэрэгцээгээр тоглолтын дүрэм өөрчлөгдөж улам боловсронгуй болсоор байв. Жишээ нь:

1900 онд аль нэг баг нь түрүүлж 21 оноо авахад нэг ээлжийн тоглолт дуусна. Тоглолтын өндөр 7 фут (213 см), шугамын өргөн нь талбайн хэмжээнд хамаарна.

1912 онд талбайн хэмжээ 35*60 фут (10.6-18.2 м), торны өндөр 7.5 фут (228 см), торны өргөн нь 3 фут (91 см), тоглогчид давуулалт алдсанахаа дараа өөрчлөгдөнө.

1917 онд торны өндөр 8 фут (243 см), нэг ээлжийн тоглолт 15 оноо хүртэл үргэлжилнэ.

1918 онд багийн бүрэлдэхүүнийг 6 тоглогчоор тогтоох

1921 онд талбайг дунд шугамаар хоёр тэнцүү хэсэгт хуваах

1922 онд нэг баг талдаа бөмбөгөнд 3 удаа хүрэхийг зөвшөөрөх

1923 онд талбайн хэмжээ 30*60 фут (9.1-18.2 м), хоёр багийн оноо 14:14 болсон үед эхэлж 2 оноо илүү авсан багийг хожсонд тооцох